

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авахыг харьяа гаалийн газар хороодод чиглэл болгон ажиллаж байна. Гаалийн ерөнхий газраас энэ онд тендерийн урилга нийтлэх үйлчилгээ, Гашуунсухайт дахь гаалийн газарт суурин компьютер худалдан авахаар цахим дэлгүүрээс судалгаа хийж, ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулагдсан. Мөн жил бүр худалдан авалт хийдэг барааг судалж Гаалийн хяналт шалгалтад ашиглагддаг нэг удаагийн троссон улаан ломбыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.